



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Хурлын хороог хуралдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолын хавсралтын 5.1.2 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 04 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хурлын байгууллагын тасралтгүй, байнгын хэвийн үйл ажиллагааг хангах, тогтоол шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороог хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.

2.Хурлын хорооны ажиллах хуваарь, хэлэлцэх асуудал бүхий удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.


3.Хурлын хороо ажиллахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дугаар захирамжийн хавсралт



УДИРДАМЖ

Хурлын хороог хуралдуулах тухай

Нэг.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороо батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээ, үйл ажиллагаатай танилцаж, санал, дүгнэлт боловсруулна.

Хоёр.Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтэс, албад Хурлын хороог шаардлагатай мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, ажиллах нөхцөлөөр хангана.

Гурав.Хурлын хороо хуралдахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлнэ.

Дөрөв.Хурлын хороо хэлэлцсэн асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн дотор Хурлын даргад эргэн танилцуулна.

Тав. Хорооны ажиллах хуваарь, хэлэлцэх асуудал:

№	Хурлын хороод	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах хэлтэс, алба
1.	Төсвийн зарцуулалтын хяналтын хороо	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт гүйцэтгэлийн удирдлага, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс болон Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаатай танилцах, төсвийн зарцуулалтад хяналт хийх (Улс, Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийгдсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, 2024-2025 он дамжин, 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний явц, хэрэгжилт)	1/29-ний өдрийн 10 ⁰⁰ цагт ЗДТГ-ын Хурлын танхимд	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба